



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 8/20

Улаанбаатар хот

Ажил хүлээн авах комисс томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Иргэний хуулийн 351 дүгээр зүйлийн 351.1.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Зорчигч үйлчилгээний цогцолборыг цагт 300 зорчигчид үйлчлэх хүчин чадалтай болгон өргөтгөх болон бусад инженерингийн барилга байгууламжуудын ажлын зураг төсөл, төсвийг боловсруулах/Увс/ ИНЕГ/ХО/ТББ/ЗҮ-06/19 дугаартай гэрээт ажил хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга:

Б.Ганхуяг

(Иргэний нисэхийн ерөнхий газрын Агаарын  
навигаци, нисэх буудлын бодлого  
зохицуулалтын газрын менежер)

Гишүүд:

Г.Бат-Алдар

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Нисэх  
буудлуудын үйлчилгээний газрын  
мэргэжилтэн)

Б.Амартүвшин

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөрөнгө  
оруулалт, захиалагчийн албаны дарга)

С.Даваасүрэн

(Иргэний нисэхийн ерөнхий газрын Санхүү,  
хөрөнгө оруулалтын газрын тооцооны  
нягтлан бодогч)

17120 0115

Нарийн бичгийн дарга:

Х.Рэнцэнпил

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөрөнгө  
оруулалт, захиалагчийн албаны Төлөвлөлт,  
гүйцэтгэлийн тасгийн инженер)

2. Гэрээний тусгай нөхцөл, ажлын даалгавар, холбогдох баримт бичиг, стандарт норм дүрэмд дурдсан шаардлагуудын дагуу шалган хүлээн авах, санхүүгийн бүртгэлд тусгуулах, комиссын акт, холбогдох бусад материалыг бүрдүүлж, Хөрөнгө оруулалт, захиалагчийн албанд хүргүүлэхийг Ажил хүлээн авах комисс (Б.Ганхуяг)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.МӨНХТУЯА